



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны *03* сарын *13* өдөр

Дугаар *114*

Хараат

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Замын улаан багийн нутаг “Ланс” гэдэг газарт өвөлжиж байгаа малчин М.Мөнхтогтохын суурьт малын гоц халдварт бог малын Мялзан өвчин илэрсэн тул 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Голомтын хүрээ координат, цэгийг тогтоож ажиллахыг үүрэг болгосугай.

3. Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан малын гоц халдварт бог малын Мялзан өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд Гамшигаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг сумын Шуурхай штабын дарга (Ш.Мөнх-Оргил)-д даалгасугай.

4. Хорио цээрийн бүсэд байгаа малд шинжилгээ, үзлэг тандалт, ариутгал халдвартайжүүлэлтийн ажлыг зохион байгуулахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч Ж.Чулуунбатад үүрэг болгосугай.

5. Малчид иргэд олон нийтэд малын гоц халдварт бог малын Мялзан өвчинөөс урьдчилан сэргийлэх, гарын авлаг, мэдээ мэдээллийг цахимаар олон нийтэд хүргэх, голомт сэжигтэй бүс нутгийн малчдад малын хариуллага маллагаатай байлгаж, хорио цээрийн дэглэмийн журмыг мөрдөж ажиллах талаар мэдээл өгөхийг МЭТасгийн дарга Т.Өлзийбат, БЗДарга нарт үүрэг болгосугай.

6. Дээрх үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгийн зардлын тооцоог гаргахыг санхүү албаны дарга (Б.Цэндмаа), нябо (Ж.Чулуунтогтох) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ЭРДЭНЭСАЙХАН

